



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/69

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд голоос 5000 га газар услах услалтын системийн толгойн барилга, суваг, хоолойн зураг төсөв /Буянт сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын
ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Батзол - "Мянган угалзат" Орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын нягтлан бодогч

Д.Дариймаа -Төрийн бус байгууллагын төлөөлөл

М.Отгонханд - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Х.Дэмид -Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020 Тг А/69 Ч
02 00403